



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/441

Есөнбулаг

Цэргийн дүйцүүлэх албанаас
хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан (Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах журам)-ын 5.3, 5.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэргийн дүйцүүлэх албанд 2022 онд элсэн орж алба хаах хугацаандаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр заасан газарт ирээгүй, оногдуулсан үүргийг биелүүлэхээс зайлсхийж цэргийн штабтай байгуулсан гэрээ болон дүйцүүлэх албаны журмыг удаа дараа зөрчиж тайлан мэдээ ирүүлээгүй Нямдорж Бат-Эрдэнэ (ДР98080315), Чинзориг Төрмандах (ДЮ00261453), Пүрэвдорж Сүхбаатар (ДК99101935) нарыг 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрөөр дуусгавар болгон гэрээг цуцлан цэргийн дүйцүүлэх албанаас хассугай.

2.Цэргийн дүйцүүлэх албанаас хасагдсан иргэдтэй тооцоог хийж захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цэргийн штаб, хурандаа (Д.Төмөрбаатар)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

